**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Халхгол сумын Музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код: ДОА-2021/57/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2021 он


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Аудитор: Э.Нандинчимэг
Утас: 7000-3775 Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ЗТХС | Зам тээвэр хөгжлийн сайд |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....9
3.Аудитын тайлан....10
3.1. Ерөнхий зүйл....10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт....10
3.4. Материаллаг байдал....10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....11
3.7. Шилэн дансны мэдээлэл....12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....12
3.9. Аудитын илрүүлэлт....12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....14

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.26 № 307

танай ________ -ны № ____________ -т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ
СУМЫН МУЗЕЙН ЭРХЛЭГЧ
А.ЧИНБАЯН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Музей 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Халхгол сумын Музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Халхгол сумын Музейн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 94 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020320

.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **21,780,203.83** | **33,890,272.83** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 21,780,203.83 | 33,890,272.83 |
| **351** | **Түүхий эд материал** | 50,000.00 | 50,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 50,000.00 | 50,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 21,730,203.83 | 33,840,272.83 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,305,207.00 | 3,488,696.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,186,956.83 | 29,763,956.83 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 238,040.00 | 587,620.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,228,573,139.49** | **1,239,890,367.49** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,228,573,139.49 | 1,239,890,367.49 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,122,380,639.61 | 1,133,697,867.61 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 784,603,414.56 | 784,603,414.56 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (52,841,602.56) | (52,841,602.56) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 20,800,000.00 | 20,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (20,800,000.00) | (20,800,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 49,094,009.75 | 49,448,337.75 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (14,705,144.68) | (14,705,144.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,418,068.00 | 23,255,968.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,431,138.76) | (11,431,138.76) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 270,976,969.98 | 288,701,969.98 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 100,012,300.00 | 93,412,300.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (26,746,236.68) | (26,746,236.68) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 106,192,499.88 | 106,192,499.88 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (577,500.12) | (577,500.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 106,000,000.00 | 106,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,250,353,343.32** | **1,273,780,640.32** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,250,353,343.32** | **1,273,780,640.33** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,250,353,343.32 | 1,273,780,640.33 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 352,789,793.00 | 352,789,793.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 246,789,793.00 | 246,789,793.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 187,819,653.08 | 211,246,950.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 63,346,850.77 | 187,819,653.08 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 124,472,802.31 | 23,427,297.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 709,743,897.24 | 709,743,897.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,250,353,343.32** | **1,273,780,640.32** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **353,888,779.73** | **179,678,033.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **176,025,379.73** | **21,505,333.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 176,025,379.73 | 21,505,333.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 176,025,379.73 | 10,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,500,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 169,525,379.73 | 10,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 11,021,333.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 484,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **177,863,400.00** | **158,172,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 118,492,900.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 118,492,900.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,370,500.00 | 19,931,400.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,100,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,707,000.00 | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,563,500.00 | 19,631,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 138,241,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 138,241,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **229,185,977.42** | **156,250,736.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **229,185,977.42** | **156,250,736.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 228,563,415.42 | 143,725,259.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 79,835,000.00 | 90,447,615.23 |
| 210101 | Үндсэн цалин | 79,835,000.00 | 90,447,615.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,942,800.00 | 11,093,383.67 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,145,748.49 | 7,906,820.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 848,339.00 | 930,214.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 653,071.35 | 744,171.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 117,785.56 | 137,470.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,177,855.60 | 1,374,707.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,386,428.00 | 17,304,744.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,200,000.00 | 4,356,324.21 |
| 210302 | Түлш, халаалт | 13,586,428.00 | 12,798,420.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,192,702.00 | 17,971,016.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,322,002.00 | 540,036.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,960,900.00 | 2,490,760.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 440,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,839,700.00 | 2,078,150.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,770,100.00 | 1,553,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 10,868,370.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,065,538.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,065,538.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,739,286.00 | 3,565,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,200,000.00 | - |
| 210602 | Тавилга | 396,600.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 17,142,686.00 | 3,565,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,492,000.00 | 2,053,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,492,000.00 | 2,053,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,802,300.00 | 608,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,405,500.00 | 195,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,000.00 | 118,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 59,900.00 | 48,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16,500.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 42,400.00 | 67,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 64,107,361.42 | 681,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,717,000.00 | 681,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 62,390,361.42 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 622,562.00 | 12,525,476.89 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 12,183,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 12,183,700.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 622,562.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 622,562.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 341,776.89 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 341,776.89 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **124,702,802.31** | **23,427,297.00** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **124,702,802.31** | **23,427,297.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 184,363,400.00 | 158,172,700.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,500,000.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,500,000.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,500,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,500,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 177,863,400.00 | 158,172,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 118,492,900.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 118,492,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 59,370,500.00 | 19,931,400.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,100,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,707,000.00 | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,563,500.00 | 19,631,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 138,241,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 138,241,300.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 184,363,400.00 | 158,172,700.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 184,363,400.00 | 158,172,700.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 183,740,838.00 | 145,647,223.11 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 79,835,000.00 | 88,624,398.90 |
| 210101 | Үндсэн цалин | 79,835,000.00 | 88,624,398.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,942,800.00 | 12,916,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,756,000.00 | 8,851,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 637,400.00 | 813,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 159,300.00 | 1,016,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 796,700.00 | 202,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,593,400.00 | 2,032,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,300,000.00 | 17,654,324.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,200,000.00 | 4,356,324.21 |
| 210302 | Түлш, халаалт | 12,500,000.00 | 13,148,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 150,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,499,302.00 | 11,175,635.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,389,102.00 | 723,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,732,200.00 | 2,490,760.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 440,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 12,878,000.00 | 3,996,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,200,000.00 | 3,525,825.00 |
| 2105 | Нормативт зардал | 3,877,100.00 | 6,002,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,877,100.00 | 6,002,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,525,336.00 | 5,691,465.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,750,000.00 | 1,164,265.00 |
| 210602 | Тавилга | 2,480,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 20,295,336.00 | 4,527,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,492,000.00 | 2,053,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,492,000.00 | 2,053,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,802,300.00 | 608,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,405,500.00 | 195,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,000.00 | 118,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 59,900.00 | 48,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16,500.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 42,400.00 | 67,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,467,000.00 | 921,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,467,000.00 | 921,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 622,562.00 | 12,525,476.89 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 12,183,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 12,183,700.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 622,562.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 622,562.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 341,776.89 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 341,776.89 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 352,789,793.00 | 709,743,897.24 | 187,819,653.08 | 0.00 | 1,250,353,343.32 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **352,789,793.00** | **709,743,897.24** | **187,819,653.08** | **0.00** | **1,250,353,343.32** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **352,789,793.00** | **709,743,897.24** | **187,819,653.08** | **0.00** | **1,250,353,343.32** |
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **352,789,793.00** | **709,743,897.24** | **187,819,653.08** | **0.00** | **1,250,353,343.32** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **352,789,793.00** | **709,743,897.24** | **187,819,653.08** | **0.00** | **1,250,353,343.32** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 23,427,297.00 | 0.00 | 23,427,297.00 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **352,789,793.00** | **709,743,897.24** | **211,246,950.09** | **0.00** | **1,273,780,640.33** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 124,992,900.00 | 124,370,338.00 | 138,241,300.00 | 137,899,523.11 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 124,992,900.00 | 124,370,338.00 | 138,241,300.00 | 137,899,523.11 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 124,992,900.00 | 124,370,338.00 | 126,057,600.00 | 125,715,823.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 79,670,000.00 | 79,047,438.00 | 88,624,400.00 | 88,624,398.90 |
| 210101 | Үндсэн цалин | 79,670,000.00 | 79,047,438.00 | 88,624,400.00 | 88,624,398.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,942,800.00 | 9,942,800.00 | 12,916,600.00 | 12,916,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,756,000.00 | 6,756,000.00 | 8,851,700.00 | 8,851,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 637,400.00 | 637,400.00 | 813,600.00 | 813,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 159,300.00 | 159,300.00 | 1,016,200.00 | 1,016,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 796,700.00 | 796,700.00 | 202,800.00 | 202,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,593,400.00 | 1,593,400.00 | 2,032,300.00 | 2,032,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,300,000.00 | 17,300,000.00 | 17,956,200.00 | 17,654,324.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,200,000.00 | 4,200,000.00 | 4,658,200.00 | 4,356,324.21 |
| 210302 | Түлш, халаалт | 12,500,000.00 | 12,500,000.00 | 13,148,000.00 | 13,148,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 600,000.00 | 150,000.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,824,200.00 | 7,824,200.00 | 3,187,000.00 | 3,147,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,200,000.00 | 464,200.00 | 464,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,124,200.00 | 2,124,200.00 | 2,242,800.00 | 2,242,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 300,000.00 | 480,000.00 | 440,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | - |
| **2105** | **Нормативт зардал** | 3,877,100.00 | 3,877,100.00 | 2,070,000.00 | 2,070,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,877,100.00 | 3,877,100.00 | 2,070,000.00 | 2,070,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,054,000.00 | 4,054,000.00 | 357,300.00 | 357,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,054,000.00 | 4,054,000.00 | 357,300.00 | 357,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,008,000.00 | 1,008,000.00 | 350,000.00 | 350,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,008,000.00 | 1,008,000.00 | 350,000.00 | 350,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,316,800.00 | 1,316,800.00 | 596,100.00 | 596,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 920,000.00 | 920,000.00 | 183,000.00 | 183,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 | 180,000.00 | 180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,000.00 | 118,000.00 | 118,000.00 | 118,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 59,900.00 | 59,900.00 | 48,100.00 | 48,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16,500.00 | 16,500.00 | | |
| 210807 | Газрын төлбөр | 42,400.00 | 42,400.00 | 67,000.00 | 67,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - | 12,183,700.00 | 12,183,700.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - | 12,183,700.00 | 12,183,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | 12,183,700.00 | 12,183,700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 124,992,900.00 | 124,370,338.00 | 138,241,300.00 | 138,241,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 118,492,900.00 | 117,870,338.00 | 138,241,300.00 | 138,241,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 118,492,900.00 | 117,870,338.00 | 138,241,300.00 | 138,241,300.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **19,931,400.0** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **19,931,400.0** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 19,931,400.0 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 8,028,535.0 | |
| 210401 | Бичиг хэрэг | - | 258,800.0 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 247,860.0 | |
| 210404 | Ном, хэвлэл | - | 3,996,050.0 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 3,525,825.0 | |
| **2105** | **Норматив зардал** | - | 3,932,000.0 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 3,932,000.0 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 5,334,165.0 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,164,265.0 | |
| 210604 | Урсгал засвар | - | 4,169,900.0 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 1,703,200.0 | |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 1,703,200.0 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 12,500.0 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 12,500.0 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 921,000.0 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 921,000.0 | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг А.Чинбаян танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ы хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол сумын музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Халхгол сумын музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Манай байгууллага соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах үүрэг хүлээдэг. Иймд эдгээр түүхийн дурсгалт зүйлсийн талаарх мэдлэг, мэдээллийг хүүхэд, залуучууд олон нийтэд хүргэх тал дээр анхаарч ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Халхгол сумын музейн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Халхгол сумын музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 156,250.74 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 3,125.014 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Халхгол сумын музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,042.8 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 21,780.2 | 33,890.3 | 12,110.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,228,573.1 | 1,239,890.4 | 11,317.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,250,353.3** | **1,273,780.6** | **23,427.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,250,353.3 | 1,273,780.6 | 23,427.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,250,353.3** | **1,273,780.6** | **23,427.3** |

Бараа материалын дансны үлдэгдэл 33,890.3 мянган төгрөг болж 12,110.1 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг болон хангамжийн бараа материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,239,890.4 мянган төгрөг болж 11,317.3 мянган төгрөгөөр өссөн нь түүх соёл, музейн дурсгалт зүйлсийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 1,164. мянган төгрөгийн хөрөнгөөр, хандиваар 11,021.33 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 4,868.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Халхгол сумын Музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 174,210.7 мянган төгрөгөөр буюу 51 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 72,935.24 мянган төгрөгөөр буюу 68 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь бараа ажил үйлчилгээний зардал буурснаас шалтгаалсан байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 138,241.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 138,241.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 138,241.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 138,241.3 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 138,241.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт урсгал үйл ажиллагаанд 125,715.8 мянган төгрөгийг зарцуулж 12,525.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 126,057.6 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь гэрэл цахилгааны зардал, шуудан холбоо интернэтийн төлбөрийн зардал буурсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өөрийн үйл ажиллагааны орлогоос 19,931.4 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 8,028.5 мянган төгрөг, норматив зардал, томилолт зочны зардалд 1,703.0 мянган төгрөг урсгал засварт 4,170.0 мянган төгрөг зарцуулжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Санхүүгийн тайлангийн хагас жилийн 83,175.4 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23,776.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 725.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 23,040.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар хуулийн хэрэгжилттэй холбоотой 23,776.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 725.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 23,040.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант оны томилолтын зардалд 2,053.2 мянган төгрөгийн олгосон ба дахин тооцоолол хийхэд 525.8 мянган төгрөгөөр илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 200.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант оны эцэст үндсэн хөрөнгийн тооллого нь дэлгэрэнгүй бүртгэл дэх дүнгээс 4,644.5 мянган төгрөгөөр дутуу, 7,341.7 мянган төгрөгийн бараа материалын тооллого дутуу, ном түлшний тооллогыг хийгээгүй нийт 11,988.2 мянган төгрөгийн хөрөнгө дутуу тоологдсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2 дахь "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд гарсан зардлаас 11,052.3 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25

Аудитын нэр: ***Халхгол сумын музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ДОА-2021/51/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: Халхгол сумын Музей

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үндсэн хөрөнгийн тооллогын тулгалтаар тоног төхөөрөмж 4,479.5 мянган төгрөг, тавилга эд хогшил 165.0 мянган төгрөгөөр дутуу тоологдсон байна. БМ-ын бичиг хэргийн материал 266.2 мянган төгрөг, аж ахуйн материал 7,077.5 мянган төгрөгөөр тус тус дутуу тоологдсон байна. Ном түлшний тооллогыг хийгээгүй байна. | 11,988.2 | Албан шаардлага өгөх | Музейн эрхлэгч Нягтлан бодогч | А.Чинбаян О.Болормаа |
| 2 | Нийт 140 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба 1 мэдээллийг хугацаа хоцорч оруулсан байна. Үүнд: Санхүүгийн тайлан (Хагас жилээр) мэдээллийн 83,175.4 мянган төгрөгийн дүнтэй гүйлгээг хоцорч байршуулсан байна | 0.0 | Албан шаардлага өгөх | Музейн эрхлэгч Нягтлан бодогч | А.Чинбаян О.Болормаа |
| 3 | Томилолтын зардалд 2,053.2 мянган төгрөгийн зардал зарцуулсан ба холбогдох баримтуудтай тулгахад хоногийг илүү тооцоолон олгосон байна. Илүү тооцоолон 525.8 мянган төгрөгийг олгосон байна. | 525.8 | Төлбөрийн акт тогтоох | Музейн эрхлэгч Нягтлан бодогч | А.Чинбаян О.Болормаа |
| 4 | Батлагдсан төсөв 2,242.8 мянган төгрөг, батлагдсан төсөв хэтрээгүй ч жишиг нормоор тооцоолоход 200.0 мянган төгрөгийн илүү зарцуулалттай. | 200.0 | Төлбөрийн акт тогтоох | Музейн эрхлэгч Нягтлан бодогч | А.Чинбаян О.Болормаа |
| 5 | Төлбөрийн цахим баримтад АТҮТӨВ 33.0 мянган төгрөг, БЭТАС 240.0 мянган төгрөг, Дорнод бүсийн эрчим хүчний систем 3,565.9 мянган төгрөг, Их замын өгөөж 7,095.3 мянган төгрөг, Практикал даатгал 118.0 мянган төгрөг нийт 11,052.3 мянган төгрөгийн баримт и-баримт төлбөрийн системд илгээгдээгүй байна. | 11,052.3 | Албан шаардлага өгөх | Музейн эрхлэгч Нягтлан бодогч | А.Чинбаян О.Болормаа |
| **ДҮН** | | **23,776.3** | | | |